ГАДААДЫН ИРГЭН, ХАРЬЯАТЫН ГАЗРЫН БАРУУН БҮС ДЭХ ГАЗРЫН
МЭРГЭЖИЛТЭН Э.АЛТАНТУНГАЛАГИЙН 2024 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН ТАЙЛАН

Нэг. Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт

| д/д | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Шалгуур үзүүлэлт | Гүйцэтгэлийн түвшин: Суурь түвшин | Гүйцэтгэлийн түвшин: Хүрэх түвшин | Гүйцэтгэлийн түвшин: Хүрсэн түвшин(биелэлт) | Эхэлсэн, дууссан хугацаа | Биелэлтийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| Зорилт 1: “Хилийн боомтод холбогдох хуулийн дагуу гадаадын иргэдэд виз олгох, бүртгэл хасалт хийх, хилээр зорчих гадаадын иргэдэд хяналт тавих” | | | | | | | |
| 1 | Арга хэмжээ 1.1 Хилийн боомтод визгүй ирсэн гадаадын иргэнд зохих ангиллын дагуу холбогдох журамд нийцүүлэн виз олгох | Виз олгосон тоо, үйлчилгээ үзүүлсэн иргэдийн тоо | 100 | Үйлчилгээг холбогдох хууль тогтоомжид заасны дагуу түргэн шуурхай хүргэнэ. | Тайлант хугацаанд хариуцсан хэсгийн Булган авто замын боомтод виз, зөвшөөрлийн газраас ирүүлсэн 7 иргэн, аж ахуйн нэгжид олгосон 11 удаагийн визийн зөвшөөрлийг үндэслэн Хятадын 75 иргэнд зохих ангилал, төрөл, зориулалтын виз олгосон. Үүнд: Хятадын 44 иргэнд энгийн зэргийн, C3 ангиллын, нэг удаагийн төрөлтэй, орох зориулалтай виз, Хятадын 2 иргэнд энгийн зэргийн K1 ангиллын, олон удаагийн төрөлтэй, орох зориулалттай виз, Хятадын 1 иргэнд энгийн зэргийн F1 ангиллын, нэг удаагийн төрөлтэй, орох зориулалттай виз, Хятадын 28 иргэнд энгийн, зэргийн K1 ангиллын, нэг удаагийн төрөлтэй, орох зориулалтай визийг тус тус олгосон байна. | 01-06 | 80 |
| 2 | Арга хэмжээ 1.2 Монгол улсад оршин суух зөвшөөрөлтэй гадаадын иргэний оршин суух зөвшөөрөлд хасалт хийх | -Алдаа дутагдалгүй үйлчилгээ үзүүлэх<br>-Үзүүлсэн | 100 | Гадаадын иргэнд түр ирэгчийн бүртгэл хасалт хийх, оршин суух зөвшөөрлийн хасалт хийх үйлчилгээг хийх | Тайлант хугацаанд оршин суух зөвшөөрлийн хасалт хийгдээгүй болно. | 01-06 | |

| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | үйлчилгээний тоо | | үйлчилгээг түргэн шуурхай хүргэнэ. | | | |
| 3 | Арга хэмжээ №1.3. Батлагдсан хуваарийн дагуу хилийн боомтод үүрэг гүйцэтгэж, гадаадын иргэдийн шилжилт хөдөлгөөнд хяналт тавих, баримт бичигт үзлэг шалгалт хийх | Улсын хилээр зорчигч гадаадын иргэдэд хяналт тавьсан тоо | 100 | Хилийн боомтоор зорчигч гадаадын иргэний шилжилт хөдөлгөөнд хяналт тавих. | 2024 оны 01 дүгээр улиралд боомтод ажиллах хуваарийн дагуу 01 дүгээр сарын 02-ноос 01 дүгээр сарын 31-ны хооронд Бургастай авто замын боомтод ажилласан. Тус боомтоор орох чиглэлд Хятадын 2042 иргэн, гарах чиглэлд Хятадын 2042 иргэн нийт 1 орны 4084 /давхардсан тоогоор/ иргэний мэдээлэлд ISM программаар хяналт тавьсан. 2024 оны 02 дугаар улиралд боомтод ажиллах хуваарийн дагуу Ховд аймгийн Булган авто замын боомтод 04 дүгээр сарын 01-ний өдрөөс 04 дүгээр сарын 30-ны хооронд ажилласан. Тус хугацаанд Булган авто замын олон улсын боомтоор орох чиглэлд Хятадын 226, Оросын 1, Франц 1, Германы 2, Казахсаны 12 иргэн, гарах чиглэлд Хятадын 129, Оросын 1, Казахстаны 11, Францын 1, Нидерландын 1, Британи 1 нийт 7 орны 403 гадаадын иргэн хил нэвтэрсэн бөгөөд баримт бичигт үзлэг шалгалт хийж виз, оршин суух, түр ирэгчийн бүртгэлийн талаар зөвлөгөө мэдээлэл өгч ажилласан. | 01-06 | 95 |
| Зорилт 2: “Хууль тогтоомжийн дагуу аймаг орон нутгийнхаа хэмжээнд хяналт тавьж ажиллах” | | | | | | | |
| 4 | Арга хэмжээ №2.1. Хил орчмын нутаг дэвсгэрт зорчих үнэмлэхтэй гадаадын | Хууль тогтоомжийн хэрэгжилтиг хангах, хяналт | 100 | хил орчмын нутаг дэвсгэрт зорчих үнэмлэхтэй гадаадын иргэний хөдөлгөөнд хяналт тавьсан байна. | Тайлант хугацаанд Булган авто замын боомтод хил орчмын нутаг дэвсгэрт зорчих үнэмлэхтэй Хятад улсын 4 гадаадын иргэний хөдөлгөөнд хяналт тавьж | 01-06 | 93 |

| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
|---|---|---|---|---|---|---|---|
| | иргэний хөдөлгөөнд хяналт тавих | тавьсан гадаадын иргэдийн тоо | | | ажилласан. | | |
| 5 | Арга хэмжээ 2.2 Хууль тогтоомжид заасан үндэслэлийн дагуу зөрчил гаргасан гадаадын иргэнийг Монгол улсаас албадан гаргах, Монгол Улсаас албадан гаргасан, гарахыг түдгэлзүүлсэн гадаадын иргэний зорчих хөдөлгөөнд хяналт тавих, | Албадан гаргагдсан гадаадын иргэдийн тоо | 100 | Монгол Улсын Улсын хил нэвтрэх эрхийг түдгэлзүүлсэн гадаадын иргэнийг Монгол Улсын хил нэвтрэхээс урьдчилан сэргийлж, хяналт тавьсан байна. | Тус хугацаанд албадан гаргагдсан, хориг арга хэмжээ авагдсан, гарах сануулга авсан, албан шаардлага хүргүүлсэн гадаадын иргэн байхгүй. | 01-06 | — |
| 6 | Арга хэмжээ №2.3. Хилийн боомт болон орон нутагт үйл ажиллагаа явуулдаг хууль, хяналтын байгуулагуудтай өдөр тутмын хамтын ажиллагаатай ажиллах | Хуулийн хэрэгжилт хангагдсан байна. | 100 | Хууль тогтоомж, дүрэм журмыг үйл ажиллагаандаа хэрэгжүүлсэн байна. | Холбогдох хууль хяналтын байгууллагатай өдөр тутам хамтран ажиллаж, тухай бүр сургалтуудыг авч ажилласан байна. | 01-06 | 90 |
| 7 | Арга хэмжээ 2.4 Иргэн аж ахуйн нэгжид хууль эрх зүйн зөвлөгөө мэдээлэл өгөх. | Зөвлөгөө мэдээллийн төрөл, тоо | 100 | Байгууллагын үйл ажиллагаанд мөрдөж байгаа хууль тогтоомж, дүрэм журам, заавар, үйлчилгээ авахтай холбоотой мэдээллээр иргэдийг хангаж ажилласан байна. | Байгууллагын үйл ажиллагаатай холбоотой зөвлөгөө мэдээлийн callpro 18001882 утасаар 1084 иргэнд зөвлөгөө мэдээлэл өгч ажиллсан. Визийн зөвшөөрөл, оршин суух зөвшөөрөл болон цахимаар хэрхэн бүртгүүлэх талаар биечлэн 11 иргэнд зөвлөгөө мэдээлэл өгч ажилласан. | 01-06 | 95 |
| Зорилт 3: “Төрийн жинхэнэ албан хаагчийн нийтлэг үүргийг хэрэгжүүлж ажиллах” | | | | | | | |
| 8 | Арга хэмжээ №3.1. Төрийн жинхэнэ албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулж батлуулах, төлөвлөгөөний биелэлт, шаардлагатай мэдээллийг | Батлагдсан гүйцэтгэлийн төлөвлөгөө, түүний тайлангийн үнэлгээ | 100 | Өөрийн 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг боловсруулан нэгжийн даргаар батлуулж, эхний хагас жилийн тайланг холбогдох | ТЖАХ-ийн 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг 2024 оны 01 дүгээр сарын 15-ны өдөр нэгжийн даргаар батлуулсан. 2024 оны хувийн ашиг сонирхлын болон хөрөнгө орлогын Мэдүүлгийг хуульд заасан хугацаанд нь үнэн зөв бөглөж, | 01-06 | 95 |

| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
|---|---|---|---|---|---|---|---|
| | Тогтоосон хугацаанд гаргаж, холбогдох нэгж, албан тушаалтанд хүргүүлэх | | | хугацаанд тайлагнаж, үнэлүүлсэн байна. Боловсруулж буй баримт бичигт холбогдох хууль, журам, стандартыг тогтмол баримтлах, хөрөнгө орлогын мэдүүлгийг тогтоосон хугацаанд мэдүүлэн, холбогдох албан хаагчид хүргүүлсэн байна. | баталгааны маягтыг гарган тус газрын захиргааны ахлах мэргэжилтэн Ц.Одгэрэлд хүлээлгэн өгсөн. 2024 оны 05 дугаар сарын визийн зөвшөөрлийн тайланг гаргаж төвийн чиглэлийн ахлахуудад мэйлээр хүргүүлсэн. | | |
| 9 | Арга хэмжээ 3.2 Удирдлагаас өгсөн хууль ёсны үүрэг даалгаврыг биелүүлэх; | Удирдлагаас өгсөн үүрэг даалгаврын тоо | 100 | Үүрэг даалгаврыг хуульд тогтоомжийн дагуу биелүүлсэн байна. | Удирдлгаас ирсэн 2 ахлах мэргэжилтнүүдээс ирсэн 6 үүрэг даалгаварыг цаг тухай бүрт нь биелүүлж ажилласан. | 01-06 | 92 |
| 10 | Арга хэмжээ 3.3 Байгууллагаас зохион байгуулж буй олон нийтийн арга хэмжээнд идэвхтэй оролцох; | Зохион байгуулж оролцсон арга хэмжээний тоо | 100 | Олон нийтийн арга хэмжээнд идэвхтэй оролцсон байна. | Ховд аймгийн Засаг даргын Тамгын газраас зохион байгуулж буй "Эв нэгдэл аяны нээлт, бие бялдрын түвшин тогтоох сорилд албан хаагчдын хамт хамрагдсан. Ховд аймгийн Онцгой байдлын газраас зохион байгуулсан Газар хөдлөлтөөс урьдчилан сэргийлэх, таниулах бүх нийтийн дадлага сургуулилтанд албан хаагчдын хамт хамрагдсан. | 01-06 | 93 |

## Нэмэлт үүрэг даалгавар (арга хэмээ)-ны биелэлт

| д/д | Үүрэг даалгавар (арга хэмжээ) | Шалгуур үзүүлэлт | Гүйцэтгэлийн түвшин | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин(биелэлт) | Эхэлсэн, дууссан хугацаа | Биелэлт ийн хувь |
| 1 | Үүрэг даалгавар (арга хэмжээ) 1. Хариуцлагатай эргүүл жижүүрээр ажиллах | Тогтсон цагуудад төвийн эргүүл, жижүүртэй | - | Тогтсон цагуудад төвийн эргүүл, жижүүртэй холбогдож нөхцөл байдлын мэдээг хүргүүлсэн байна. | Баруун бүс дэх газрын "Хариуцлагатай эргүүл жижүүрийн хуваарийн" дагуу шуурхай жижүүрээр 1 удаа ажиллаж тогтсон цагт нийт 3 удаа нөхцөл | 01-06 | 95 |

| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | холбогдох | | | байдлын мэдээг холбогдох албан тушаалтанд өгч, удирдлагыг мэдээ мэдээллээр ханган ажилласан. | | |
| 2 | Үүрэг даалгавар (арга хэмжээ) 2. Архивын нэгж хүлээлгэн өгөх | Хүлээлгэн өгсөн архивын нэгжийн тоо, хугацаа; | - | 2023 оны өөрийн эрхэлсэн ажлын баримт бичгийг стандартын дагуу цэгцлэн байгууллагын архивд стандартын дагуу цэгцлэн хүлээлгэн өгөх | Албан хэрэг хөтлөлтийн үндсэн заавраар дагуу 2023 оны 3 ширхэг архивын нэгжийг архивлаж архив, бичиг хэргийн эрхлэгчид хүлээлгэн өгсөн. | 01-06 | 93 |
| 3 | Үүрэг даалгавар (арга хэмжээ) 3. Албаны байранд цэвэрлэгээ хийх | Албан хаагчдын хамт цэвэрлэгээ хийх | - | Албаны байранд их цэвэрлэгээ хийсэн байх. | Албаны байр цэвэрлэх хуваарийн дагуу 7 хоног бүрийн 5 дахь өдөр албан хаагчдын хамт их цэвэрлэгээ хийсэн. | 01-06 | 95 |
| 4 | Үүрэг даалгавар (арга хэмжээ) 4. Албан хаагчдад сургалт зохион байгуулах | Нийт албан хаагчдад сургалт зохион байгуулах | - | Нийт албан хаагчдад сургалт зохион байгуулсан байна. | Байгууллагын даргын 2024 оны 02 дугаар 15-ны 01-02/09 дугаар удирдамжийн дагуу 02 дугаар сарын 26-наас 03 дугаар сарын 01-ны хооронд ГИХГ-т Дадлагжуулах сургалтад хамрагдсан. Тус сургалтаар олж авсан мэдлэг мэдээллээрээ хяналтын улсын байцаагч С.Цэцэгсүрэнтэй хамтран бүсийн газрын нийт албан хаагчдад сургалт зохион байгуулсан. | 01-06 | 95 |
| 5 | Үүрэг даалгавар (арга хэмжээ) 5. Төвөөс болон орон нутгаас ирүүлж буй судалгаанд хамрагдах | Судалгааг тухай бүрд нь үнэн зөв бөглөх | - | Судалгаанд тухай бүр хамрагдаж ажилласан байх. | Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль батлагдсантай холбогдуулан байгууллагын Ёс зүйн дэд хороог байгуулахад хорооны гишүүдэд саналаа өгсөн. Байгууллагын орон сууцны судалгаа, амьжиргааны түвшингийн судалгаа, сургалтын оролцоог тодорхойлох, төрийн албан хаагчдад зориулсан судалгаа, авлигыг мэдээлэх | 01-06 | 90 |

| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | системийг сайжруулах судалгаа, ГИХГ-ын цахим шилжилтийн үр нөлөөтэй байдлын судалгаа, өөрчлөлт шинэчлэлтэд бэлэн байдлын судалгаа, албан хаагчдын дүрэмт хувцасны загвар, төрөл, зориулалт, иж бүрдэл, ялгах тэмдэг, эдэлгээний хугацаанд өөрчлөлт оруулах, Нийгмийн баталгаа болон сургалтын төлөвлөгөө, Гадаадын иргэн, харьяатын газрын албан хаагчид цол олгох журам"-ын цолны загварын санал асуулга, албан хаагчдын 2008-2024 онд төрсөн хүүхдийн судалгаа зэрэг судалгаанд хамрагдсан. | | |
| 6 | Үүрэг даалгавар (арга хэмжээ) 6. Баруун бүс дэх газрын боомтуудын өдөр дутамын хөдөлгөөний мэдээг гаргаж, удирдлагад танилцуулах | Тогтоосон цагт мэдээг хүргүүлэх | - | Хуваарийн дагуу хөдөлгөөний мэдээг гарган, ахлах байцаагчид танилцуулсан байна. | 2024 оны 04 сарын 17-ноос 04 сарын 23-ны өдрүүдэд Бүсийн хэмжээнд ажиллаж байгаа хилийн боомтоор зорчсон гадаадын иргэдийн хөдөлгөөний мэдээ, бүсийн нөхцөл байдлын мэдээг гарган удирдлагад танилцуулан ажилласан. | 01-06 | 95 |
| 7 | Үүрэг даалгавар (арга хэмжээ) 7. Булган боомтод интернэтийн сүлжээ тавиулах | Интернэт сүлжээг хэвийн ажиллагаанд оруулах | - | Булган боомтын ажлын өрөөнд интернэт сүлжээнд холбосон байна. | Бүсийн даргаас өгсөн үүрэг даалгаварын дагуу Булган авто замын боомтын ажлын өрөөнд мобинетийн сүлжээний инженерийн хамт интернэт сүлжээг холбуулсан. | 01-06 | 92 |
| 8 | Үүрэг даалгавар (арга хэмжээ) 8. Байгууллагын гадна мод тарих | Албан хаагчдын хамт байгууллагын гадна талбайд мод тарих | - | Албан хаагчдын хамт байгууллагын гадна талбайд мод тарьсан байна. | Байгууллагын гадна талбайд албан хаагчдын хамт гацуур, улиас, хуйс зэрэг мод тарьсан. | 01-06 | 95 |
| 9 | Үүрэг даалгавар (арга хэмжээ) 9. | Байгууллагы | - | Байгууллагын гадна | Албан хаагчдын хамт | | |

| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
|---|---|---|---|---|---|---|---|
| | Байгууллагын гадна талбайн цэвэрлэгээ хийж, чулуу зөөх | н гадна талбайд байгаа том чулуунуудыг зөөж, цэвэрлэгээг хийсэн байх | | талбайд байгаа том чулуунуудыг зөөж, цэвэрлэгээг хийсэн байна. | байгууллагын гадна талбайн чулуу, хогийг түүж, зүлэгжүүлэлт хийсэн. | 01-06 | |

## Хоёр. Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний биелэлт

| д/д | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Шалгуур үзүүлэлт | Гүйцэтгэлийн түвшин | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин(биелэлт) | Эхэлсэн, дуусcан хугацаа | Биелэлт ийн хувь |
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| 1 | Арга хэмжээ №1.1.<br>Төрийн болон төрийн бус байгууллагуудаас зохион байгуулсан сургалтад хамрагдах | Мэдлэг ур чадвар дээшилсэн байна. | 100 | Мэдлэг ур чадвар дээшилсэн байна. | Ховд аймгийн Халамжийн хэлтсийн хөдөлмөрийн аюулгүй байдлын эрүүл, ахуйн зуучлал бууруулах мэргэжилтэн Ж.Амгаланшоо, Х.Отгон нарын “Зөв амьдралын хэв маяг” сэдэвт сургалт, Мэргэжилтэн П.Хатанбаатар “Төрийн албан хаагчийн ёс зүй, харилцаа хандлага” сэдэвт сургалт, Ховд аймаг дахь Сум дундын эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн шүүгч Б.Мөнхзаяа “Авлигын эсрэг хууль”-ийн тухай ойлголт сэдэвт сургалт, БОЭТ ын их эмч М.Хосбаяр, их эмч Х.Лхагвасүрэн нар “Стресс”, “Хүүхдийн бэртэл гэж юу болох” сэдэвт сургалтуудад хамрагдсан.<br>Ерөнхий газраас зохион байгуулсан “Монгол хүний сэтгэлгээ ба хандлага” “Дижитал шилжилт, | 01-06 | 90 |

| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | виртуал орчин", "Байгууллага хувь хүний санхүү төлөвлөлт", "Эрүүл амьдралын зөв дадал, зуршил" "Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийн талаарх хууль тогтоомж зохицуулалтын тухай", "Эмэгтэйчүүдийн манлайлал", "Хүүхэд хүмүүжүүлэх эерэг арга" сэдэвт сургалтуудад цахимаар хамрагдсан.<br>Байгууллагын даргын 2024 оны 02 дугаар 15-ны 01-02/09 дугаар удирдамжийн дагуу 02 дугаар сарын 26-наас 03 дугаар сарын 01-ны хооронд ГИХГ-т Дадлагжуулах сургалтад хамрагдсан.<br>Төрийн албаны зөвлөлөөс зохион байгуулсан 10 удаагийн сургалтад цахимаар хамрагдаж, Удирдлагын академийн "Авлигаас ангид төрийн алба" 1-р түвшиний сургалтад цахимаар хамрагдаж сертифкат авсан.<br>Бүсийн газраас зохион байгуулж буй Англи хэлний сургалтад хамрагдаж байна. | | |
| 2 | Арга хэмжээ №1.2.<br>Хятад хэлний мэдлэг чадвараа дээшлүүлж сургалтад хамрагдсан байх | Мэдлэг чадвар дээшилсэн байна | - | Хятад хэлний зохих мэдлэгтэй болох | Баруун бүсийн Күнзийн институтаас төрийн албан хаагчдад зориулсан хятад хэлний анхан шатны онлайн сургалтад хамрагдаж байна. | 01-06 | |

ТАЙЛАН ГАРГАСАН:
МЭРГЭЖИЛТЭН [signature] Э.АЛТАНТУНГАЛАГ

2024 оны 06 дугаар сарын 05